



ХОВД АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 10/01

Ховд

Хэлэлцэх асуудал, дотоод журам, үйлчлэх  
Ажлын албадыг батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10 дугаар  
хуралдаанаас ТОГТООХ нь:


1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10 дугаар хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 100 хувийн саналаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10 дугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, дотоод журмыг 2 дугаар хавсралтаар, хуралдаанд үйлчлэх Ажлын албадыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын 10 дугаар хуралдааны  
1 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт



АЙМГИЙН ИТХ-ЫН 10 ДУГААР ХУРАЛДААНЫ  
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1.Төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Илтгэгч нь: Аймгийн Сонгуулийн хорооны дарга Л.Батбаяр

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай

Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди

3.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн болон эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 оны зорилтын тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

4.Аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, 2019 оны батлагдсан төсвийн хэрэгжилт, 2020 оны төсвийн төслийн тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

5.Аймгийн 2020 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар аймгийн Аудитын газраас өгөх саналын тухай

Илтгэгч нь: Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар

6.Аймгийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний биелэлт, 2020 оны төлөвлөгөөний төслийн тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

7.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны “Мал эмнэлгийн ажил үйлчилгээ, шинжилгээний хөлсний норматив тогтоох тухай” 8/10 дугаар тогтоол, “Ховд аймгийн орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж сэтлэх, нөхөн сэргээх ажлын зөвшөөрөл олгох, гүйцэтгэх журам батлах тухай” 8/08 тогтоолуудыг хүчингүй болгох тухай

Илтгэгч нь: Хууль эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг


8.Орон нутгийн татварын хувь хэмжээ тогтоох тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

9.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Илтгэгч нь: Аймгийн ИТХ дахь МАН-ын бүлгийн  
дарга М.Ганзориг

---oOo---



## ДОТООД ЖУРАМ

- 1.Төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай  
/5 минут/
- 2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай  
/20 минут/
- 3.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн болон эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 оны зорилтын тухай  
/20 минут/
- 4.Аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, 2019 оны батлагдсан төсвийн хэрэгжилт, 2020 оны төсвийн төслийн тухай  
/20 минут/
- 5.Аймгийн 2020 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар аймгийн Аудитын газраас өгөх саналын тухай  
/10 минут/
- 6.Аймгийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний биелэлт, 2020 оны төлөвлөгөөний төслийн тухай  
/15 минут/
- 7.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны “Мал эмнэлгийн ажил үйлчилгээ, шинжилгээний хөлсний норматив тогтоох тухай” 8/10 дугаар тогтоол, “Ховд аймгийн орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж сэтлэх, нөхөн сэргээх ажлын зөвшөөрөл олгох, гүйцэтгэх журам батлах тухай” 8/08 тогтоолуудыг хүчингүй болгох тухай  
/5 минут/
- 8.Орон нутгийн татварын хувь хэмжээ тогтоох тухай  
Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав  
/5 минут/
- 9.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай  
Илтгэгч нь: Аймгийн ИТХ дахь МАН-ын бүлгийн дарга М.Ганзориг  
/5 минут/

10.Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, урилгаар оролцогчид үг хэлнэ.

/Хэлэлцэх асуудал тус бүрд хүн бүр эхний удаа 5 минут,  
дараагийн удаа 3 минут/

11. Хуралдаанаас гарах шийдвэр батлах

/Цаг тогтоохгүй/

12.Хуралдааныг 2 цаг тутамд 10 минутын завсарлагатайгаар товлосон өдөрт  
багтаан дуусгана.

----oOo----

Аймгийн ИТХ-ын 10 дугаар хуралдааны  
1 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

АЙМГИЙН ИТХ-ЫН 10 ДУГААР ХУРАЛДААНД  
ҮЙЛЧЛЭХ АЖЛЫН АЛБА

А. Нарийн бичгийн даргаар:

А.Түмэндэлгэр - Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын  
албаны НУБЗХ-ийн мэргэжилтэн

Г.Бадамсүрэн - Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын  
албаны ОНИХХ-ийн мэргэжилтэн

Б.Гантөмөр - Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн

Ж.Батбаяр - Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн

Б. Редакцын комиссоор:

Б.Баяртуяа - Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын  
албаны ОНИХХ-ийн дарга

С.Дорж - Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн

В. Тэмдэглэл хөтлөгчөөр:

Р.Цэцэгжаргал - Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын  
албаны НУБЗХ-ийн мэргэжилтэн

С.Батцэцэг - Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны  
НУБЗХ-ийн мэргэжилтэн

Г. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан гарах тогтоолын төсөл боловсруулах  
ажлын хэсэг:

Ахлагч: Б.Сандагсүрэн - Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга

Гишүүд: Ц.Бат-Эрдэнэ - Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Б.Амгаланбадрах - Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Д.Нямлхагва - Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Б.Амаржаргал - Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Ч.Багдал - Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

Б.Баярсүх - Аймгийн Газрын харилцаа, барилга,  
хот байгуулалтын газрын дарга



ХОВД АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 10/02

Ховд

“Хүний хөгжлийг дэмжиж бизнес, хөрөнгө  
оруулалтын үр ашгийг дээшлүүлэх жил”  
болгон зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг үндэслэн “аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай” аймагын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Пүрэвгандийн илтгэлийг хэлэлцээд аймагын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Аймагын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай” илтгэлд тусгагдсан аймагын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2019 онд дэвшүүлсэн зорилтыг хангаж ажилласныг тэмдэглээд зохион байгуулж хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнд хийсэн дүгнэлт, цаашдын дэвшүүлсэн зорилтыг сайшааж үйл ажиллагааны үр дүнг хангалттай гэж дүгнэсүгэй.

2. Аймагын хэмжээнд 2020 оныг “Хүний хөгжлийг дэмжиж бизнес, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх жил” болгон зарласугай.

3. Аймагын ИТХ-ын дарга /Г.Пүрэвганди/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

3.1. Аймагын хэмжээнд 2020 оныг хүний хөгжлийг тэтгэсэн, ажилтай, орлоготой бүтээлч, хөдөлмөрч хүнийг дэмжиж бизнесийн орчныг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтуудыг чанартай, үр дүнтэй зохион байгуулах зорилгоор “Хүний хөгжлийг дэмжиж бизнес, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан нутгийн захиргааны байгууллагуудын хүний хөгжил, бүтээн байгуулалт, ажлын байр нэмэгдүүлэх талаар хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хувийн хэвшил, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын түншлэл, иргэдийн оролцоог хангахад бүх талын дэмжлэг

0000044

туслалцаа үзүүлж хамтран ажиллаж хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж ажиллах;

3.2.Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016-2020 оны бүрэн эрхийн хугацаанд дэвшүүлсэн Стратеги зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын, Төлөөлөгч, Тэргүүлэгчид, ажлын албаны үйл ажиллагааг эрчимжүүлэн бодитой дэмжлэг үзүүлж, орон нутгийн хөгжлийг ахиулж тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд бодлогыг төвлөрүүлэн үр бүтээлтэй ажиллаж 2020 оны 3 дугаар улиралд багтаан бүрэн биелүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх

3.3.Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуультаан, ажилтнуудын хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх хяналтын чиг үүргийг бүх шатанд төлөвшүүлэх, төр, иргэний хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ажил, асуудлуудыг санаачлан зохион байгуулж үр дүнд хүргэх.

3.4.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын, Тэргүүлэгчдээс аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тэтгэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тогтвортой ажлын байр бий болгох, өрхийн орлого нэмэгдүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд санаачилгатай, шуурхай ажиллаж, шаардлагатай асуудлуудыг зохих хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ,хэрэгжилтэд тавих хяналтыг өндөржүүлэх

3.5.Аймаг, сум, багийн Нутгийн өөрөө удирдах байгууллагад ажиллаж байгаа сонгуультаануудын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, мэдлэг, мэдээллээр хангах сургалт семинарт хамруулах, туршлага судлуулах ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлэх.

3.6.Иргэний боловсрол төлөвшлийн гол асуудал болох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран чанартай, ажил хэрэгч байдлаар зохион байгуулж үр дүнд хүргэх

3.7.Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж биелэлтийг тооцож, үр дүнг аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулж ажиллах.

4.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт ЗӨВЛӨХ нь:

4.1.“Хүний хөгжлийг дэмжиж бизнес, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх жил”-ийн хүрээнд хүний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд иргэн, хамт олны идэвхийг өрнүүлэн нөөц боломждоо тулгуурласан аж ахуйг өргөтгөх,



үйлдвэрлэл үйлчилгээг нэмэгдүүлэх, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, байгаль орчноо сэргээн хамгаалах, ажиллаж амьдрах орчноо сайжруулан тохижуулах зэрэг зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж иргэн, айл өрхийн амьдралыг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах.

4.2.2016-2020 оны бүрэн эрхийн хугацааны Хурлын Стратеги төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилт болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхэд байгууллага, хамт олон, иргэдийн ажлыг уялдуулан эрчимжүүлж 2020 оны 3 дугаар улиралд багтаан биелэлтийг хангахаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах

4.3.Сум, багт хийгдэж буй хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, зураг төсөв, ажлын даалгаврын дагуу баригдаж байгаа эсэхэд нутгийн захиргааны байгууллага, иргэдийг оролцуулсан хөндлөнгийн хяналтыг тогтмол хийж чанартай, үр дүнтэй бүтээн байгуулалт бий болгоход ач холбогдол өгч ажиллах.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 10/03

Ховд

“Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны  
хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад  
үнэлэлт өгөх тухай”

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг үндэслэн “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай” аймгийн Засаг дарга Б.Дүгэржавын илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, бүтээн байгуулалтын ажлын үр дүнг 2019 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 78,4 хувь буюу хангалттай гэж дүгнэсүгэй.

2.Аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д ДААЛГАХ нь:

2.1.“Хүний хөгжлийг дэмжиж, бизнес, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх жил”-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төсөл, арга хэмжээг өргөнөөр сурталчилж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, олон улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулах;

2.2.Бизнесийн таатай орчин бүрдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгох замаар ажилгүйдлийг бууруулах, 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах;

2.3.Аймгийн “Хөрөнгө оруулалтын чуулган-2”-аар хэлэлцүүлсэн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тодорхойлох, ирээдүйн “Шинэ Ховд”-ыг цогцлоон бүтээх мега болон жижиг төслүүдийн үр ашгийг тооцоолсны үндсэн дээр хэрэгжих боломжийг судалж бодит үр дүнд хүрэхүйц төслүүдийг дэмжиж ажил хэрэг болгох;

0000047

2.4.Төрийн албаны тогтвортой байдлыг хангахад чухал түлхэц болсон Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан журмуудыг дагаж мөрдөх, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хууль дээдлэн шударга, ил тод, иргэдийн хүсэн хүлээсэн авлига, хүнд суртлаас ангид, хариуцлагатай, тунгалаг төрийн үйлчилгээг бий болгоход гол анхаарлаа хандуулж, хариуцлагыг бүх шатанд дээшлүүлэх;

2.5.Иргэн хүний хөгжлийг эрүүл биетэй, нийгмийн хэрэгцээг хангасан боловсрол мэргэжилтэй, ахуй амьдралаа зохицуулах орлоготой байх тулгуур зарчмаар иргэдийн оролцоотой тодорхойлон хэрэгжүүлж, удирдлага, зохион байгуулалтын бодлогыг оновчтой тодорхойлон хэрэгжүүлэх;


2.6.Эдийн засаг, нийгмийн салбарын хөгжлийн хүрсэн түвшинг дээшлүүлэн, хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, мэргэшсэн боловсон хүчнээр бүрэн хангах, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авч төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мөрдөж ажиллах;

2.7.Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тендерийн шалгаруулалтын ажлыг нийтэд нээлттэй болгож тухайн ажлын гүйцэтгэлийн чанар, стандартын нөхцөлийг хангуулахад захиалагчаас тавих хяналтыг өндөржүүлэх;

2.8.Хөдөө аж ахуйн болон төв, суурин газрын өвөлжилт, хаваржилтын байдалд анхаарч, хадлан тэжээл, түлээ нүүрс татан авах, нөөцлөх, байр, орон сууц, албан байгууллагуудын халаалт, дулааныг хэвийн горимд ажиллуулах талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудыг үүрэг даалгавраар хангаж, хяналт тавьж ажиллах;

2.9.Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт удаашралтай зорилтуудыг төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган 2020 оны 3 дугаар улиралд багтаан хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг улирал бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллах.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 10/04

Ховд

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд  
хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а”, 19 дүгээр зүйлийн 19.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалт “Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 оны зорилтын тухай” аймгийн Засаг дарга Б.Дүгэржавын илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 85.2 хувьтай буюу хангалттай гэж дүгнэсүгэй.

2.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.


3.Үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээ бүрийг олон нийтэд сурталчилж, шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд тусган, төрийн болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд олон нийт, хувийн хэвшлийн оролцоог ханган, үр дүнтэй түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын 2019 оны 10 дугаар  
хуралдааны 10/04 дүгээр тогтоолын  
хавсралт



АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД  
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2020 онд хүрэх түвшин, үр дүн	2020 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөгөөр/	Хариуцах байгууллага
<p><b>НЭГ.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО:</b> Олон тулгуурт ногоон эдийн засагт түшиглэсэн, бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэсэн, үйлдвэрлэл, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, эдийн засгийн өсөлтийг хангана.</p>						
<p><b>1. Эдийн засгийн бодлого зохицуулалтын чиглэлээр:</b></p>						
1.1.1	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030 /цаашид "МУТХҮБ-2030" гэх/-ын 2.1 дэх заалт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /цаашид "ЗГҮАХ" гэх/-ийн 1.1, 1.2 дахь заалт	Аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний одоогийн байгаа түвшинг бууруулахгүйгээр цаашид нэмэгдүүлнэ.	Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид "ДНБ" гэх/-ний бодит өсөлт, хувиар	5.0	-	Аймаг, сумын ЗДТГ, байгууллагууд

	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /цаашид аймгийн ЗДҮАХ гэх/-ийн 1.1.1 дахь заалт					
1.1.2	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.1.5 дахь заалт	Татварын бааз, суурийг өргөтгөж, татварын сахилгыг сайжруулан татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Татварын хэлтэс
1.1.3	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.1.6 дахь заалт	Санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулж, өр авлага барагдуулах албан даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Аймаг, сумын ЗДТГ, байгууллагууд
1.1.4	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.1.8	Орон нутгийн өмчийн харилцааны оновчтой бодлогыг тодорхойлж, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, орон нутгийн өмчит газруудын санхүүгийн үр ашгийг дээшлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	АЗДТГ, ОНӨГ
1.1.5	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.1.9	Худалдан авах ажиллагааг ил тод болгож, аж ахуйн нэгж, байгууллагуудад өрсөлдөх тэгш боломжийг хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Аймаг сумын ЗДТГ, ОНӨГ
<b>1.2 Дэд бүтэц, барилга хот байгуулалтын чиглэлээр:</b>						

1.2.1	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.5 дахь заалт	Зарим сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Батлуулсан төлөвлөгөөний тоо	2-оос доошгүй	-	АЗДТГ, ГХБХБГ, СЗДТГ
1.2.2	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.5 дахь заалт	Сумдын болон Жаргалант сумын Бичигт, Цамбагарав багийн ЦДАШ-ыг үе шаттай шинэчилж, цахилгаан хангамжийг сайжруулна.	Шинэчилсэн ЦДАШ-ын	2-оос доошгүй	Улсын төсөв	АЗДТГ, СЗДТГ, ХЦТСК
1.2.3	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.6 дахь заалт, Ногоон хөгжлийн хөтөлбөрийн 2.5 дахь заалт	Ховд хотын Нийтийн орон сууцны засвар үйлчилгээ, ашиглалтыг сайжруулах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	200,0 ОНТ	АЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ
1.2.4	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.6 дахь заалт	Ховд хотын Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, үйлчилгээг сайжруулах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	200,0 ОНТ	АЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ
1.2.5	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.76, 3.4.3 дахь заалт	Өрхийн орлого багатай ерхүүдэд хямд үнэтэй нийтийн болон амины орон сууцтай болох хөтөлбөр хэрэгжүүлж, “Хашаандаа сайхан амьдарцгаая” хөтөлбөрийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	50	2000,0 Улс, Аймаг, сумын ОНТ	Аймаг, сумын ЗДТГ

1.2.6	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.7 дахь заалт	Ховд хотын үерийн усны зайлуулах хоолой сувагчлал байгуулах, далан сэргээн засварлах ажлыг зохион байгуулна.	Байгуулсан сувагчлалын хэмжээ, м	5000,0	5000,0 Улсын төсөв	АЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ
1.2.7		Булган сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбоно.	Хэрэгжилтийн хувь	50	6200,0 Улсын төсөв	АЗДТГ, Булган сумын ЗДТГ
1.2.8	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.1.4, ЗГҮАХ-ийн 2.106 дахь заалт, Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.7 дахь заалт, Ногоон хөгжлийн хөтөлбөрийн 2.6 дахь заалт	Ховд хотын Дулааны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх, засварлах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Байгуулсан ДДТ-ийн тоо, дулааны шугам сүлжээний хэмжээ, км	ДДТөв-2 Дулааны шугам-3 км	Улсын төсөв, ОНТ	АЗДТГ, ХХ, Дулааны станцууд
1.2.9	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.1.4, ЗГҮАХ-ийн 2.106 дахь заалт, Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.7 дахь заалт, Ногоон хөгжлийн хөтөлбөрийн 2.6 дахь заалт	Ховд хотын Цэвэр, бохир усны шугамыг үе шаттайгаар шинэчилж, цэвэр усны станцын өргөтгөл, шинэчлэл хийж, айл өрхөд ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.	Шинэчилсэн шугам сүлжээ, боловсруулсан зураг төсөл, км	Зураг төсөл-26,4 Угсралт-14,5	Улсын төсөв	АЗДТГ, Шим-УС ОНӨААТҮГ
1.2.10	ТЭХТББ-ын 3.2.5, ЗГҮАХ-ийн 2.108 дахь заалт, Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.7 дахь заалт	Ховд хотын цахилгаан эрчим хүч хэрэглэгчдэд орчин үеийн ухаалаг тоолуур дэс дараатай суурилуулж, цахилгааны төлбөрийг хугацаанд нь барагдуулдаг болно.	Суурилуулсан ухаалаг тоолуурын тоо, өрхөөр	1000	Улсын төсөв, ОНТ	АЗДТГ, ХЦТСК



1.2.11	Аймгийн ЗДҮАХ-ийн 4.1.7 дахь заалт	Орон нутгийн телевизийн мэдээллийг аймаг, сумдад нэвтрүүлнэ.	Мэдээллээ цацдаг болсон ТВ-ийн тоо	2	20,0 ОНТ	АЗДТГ
1.2.12	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.7 дахь заалт	Аймгийн төвийн мэдээлэл холбооны шугам сүлжээ өргөтгөх, шинэчлэх ажлыг зохион байгуулна.	Хэрэгжилтийн хувь	50	Улсын төсөв, ОНТ	АЗДТГ, "МХС" ТӨХХК
1.2.13	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 2, ТЭХТББ-ын 3.2.6, ЗГҮАХ-ийн 2.104 дахь заалт, Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.11 дахь заалт, Ногоон хөгжлийн хөтөлбөрийн 2.3 дахь заалт	Эрдэнэбүрэний 90 мвт-ын усан цахилгаан станцын барилгын ажлыг эхлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	30	Улсын төсөв, Гадаад эх үүсвэр	ЗГ, АЗДТГ, ХЦТСК
1.2.14	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.11 дахь заалт, Ногоон хөгжлийн хөтөлбөрийн 2.3 дахь заалт	Мянгад суманд нарны эрчим хүчний 10 мвт цахилгаан станц байгуулах ажлыг эхлүүлнэ.	Барилга угсралтын ажил, хувиар	100	Дэлхийн банк	АЗДТГ, ХЦТСК, Дэлхийн банк
1.2.15	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.9 дэх заалт	Газрын тухай хууль, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагад газар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	Иргэдэд эзэмшүүлсэн, өмчлүүлсэн газрын хэмжээ, га	15	-	ГХБХБГ, СЗДТГ
1.2.16		Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө /2021-2036/-г	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	10	20,0 Улсын төсөв, Орон нутгийн	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ГХБХБГ

		боловсруулах ажлыг эхлүүлнэ.			төсөв	
1.2.17		Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын материалын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, бүсийн хэмжээнд ажиллуулах боломжийг судлах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	30	20,0 Улсын төсөв, Орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ГХБХБГ
<b>1.3. Зам, тээвэр, уул уурхай</b>						
1.3.1	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.1 дахь заалт	Булган, Байтаг боомтын хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг өргөжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	ЗТХЯ, АЗДТГ
1.3.2	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.1 дахь заалт	Авто замын хяналт шалгалтыг сайжруулж, насжилтыг уртасгана. Хяналтын постын тоог нэмэгдүүлнэ.	Ашиглалтад оруулсан постын тоо	3	-	АХБ, ЗТХЯ, АЗДТГ
1.3.3	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.107, Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.2 дахь заалт	Аймгийн төвийн авто зам, гэрэлтүүлэг /Жаргалант сум, Наран, Бичигт баг/	Барьсан хатуу хучилттай авто замын хэмжээ, км	1.9	1300, Улсын төсөв	ЗТХЯ
1.3.4	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.107, Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.2 дахь заалт	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Жаргалант сум, Баатархайрхан, Бичигт баг/	Барьсан хатуу хучилттай авто замын хэмжээ, км	0.8	150, Улсын төсөв	ЗТХЯ

1.3.5	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.121 дэх, Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.2	Хот доторх болон орон нутгийн авто зам, гүүрэн байгууламжид урсгал болон их засвар тогтмол хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	АЗДТГ
1.3.6	УТ-ын XIII.1.1.37, Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.2.6 дахь заалт	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 4.6 км /Цэцэг сум/	Хатуу хучилттай авто замын хэмжээ, км	4.9	2473, Улсын төсөв	ЗТХЯ, АЗДТГ
1.3.7	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.2.7 дахь заалт	Чоно харайхын гүүр /Дөргөн сум/	Урт метр	37	200, Улсын төсөв	ЗТХЯ
1.3.8	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.3 дахь заалт	Хот доторх автобусны зогсоолуудыг тохижуулж, нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, давтамжийг өсөн нэмэгдэж буй хэрэгцээнд тулгуурлан нэмэгдүүлнэ.	Зогсоолын тоо	5	-	ЗТХЯ
1.3.9	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.3 дахь заалт	Аймгийн төвөөс сумдын чиглэлийн зорчигч, ачаа тээвэр, шуудангийн үйлчилгээний менежментийг сайжруулна.	Хэрэгжилт, хувь	100	-	АЗДТГ
1.3.10	Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.4 дэх заалт	Булган суманд тээвэр ложистикийн төв байгуулна.	Хэрэгжилт, хувь	50	-	Хувийн хэвшил
1.3.11	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.114 дэх заалт Аймгийн ЗДҮАХ-ийн 1.4.4	Аймгийн нисэх буудлыг олон улсын ангилалд нийцүүлэн өргөтгөнө.	Хэрэгжилтийн хувь	70	-	ЗТХЯ, Гадаад эх үүсвэр